



**МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙДЫН ТУШААЛ**

2021 оны 02 сарын 01 өдөр


Дугаар A/08

Улаанбаатар хот

Г Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны A/231 дугаар тушаалаар батлагдсан “Зам, тээврийн салбарын үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах дунд хугацааны дэд хөтөлбөр”, 2021 оны A/01 дугаар тушаалаар батлагдсан “2021 оныг техник, технологийн шинэчлэлт-цахим шилжилтийн жил” болгон зарласантай холбогдуулан эдгээр тушаалын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг бодлогын удирдамжаар хангах, зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бурэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, ажиллах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Ажлын хэсгийг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж, тушаалын хэрэгжилтийн үр дүнг сар, улирал бүр танилцуулж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч /Ж.Бат-Эрдэнэ/-д даалгасугай.
3. Салбарт цахим шилжилтийг хийхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх, зарим чиг үүргийг хувийн хэвшлийн мэдээллийн технологийн томоохон дэд бүтэцтэй байгууллагад гэрээгээр хариуцуулан гүйцэтгүүлэх, төрийн үйлчилгээг E-Mongolia порталд нэгтгэх ажлыг зохион байгуулж ажиллахыг яамны газар, харьяа байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /М.Энхболд/-т үүрэг болгосугай.
5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” A/213 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Зам, тээврийн хөгжлийн сайдын  
2021 оны 01 дугаар сарын 04-ны өдрийн  
A/08 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч

Ж.Бат-Эрдэнэ

Зам, тээврийн хөгжлийн дэд сайд;

Ажлын хэсгийн дэд ахлагч

Зам, тээврийн хөгжлийн яамны Мэдээллийн технологи, стандартын хэлтсийн дарга;

Гишүүд:

Э.Шаарийбуу

Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Мэдээллийн сүлжээ, техник хангамж мэргэжилтэн;

Б.Уганбаяр

Зам, тээврийн хөгжлийн яамны Цахим зөвлөх, Интерактив ХХК-ийн захирал;

М.Баттулга

Үндэсний data төв ТӨҮГ-ын захирал;

М.Оролзод

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын Мэдээллийн технологи, бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн;

Э.Оюунгоо

“Цахим хөгжлийн үндэсний хороо”-ны ажлын албаны Мэдээллийн технологийн мэргэжилтэн;

Ч.Агиймаа

“Иргэний нисэхийн үндэсний төв”-ийн Мэдээллийн технологи, инновацийн албаны дарга;

Ц.Ган-Эрдэнэ

“Иргэний нисэхийн үндэсний төв”-ийн Мэдээллийн технологи, инновацийн албаны менежер;

А.Ванданмагсар

“Иргэний нисэхийн үндэсний төв”-ийн Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албаны Аюулгүй ажиллагаа, чанар хангалтын хэсгийн дарга

Д.Тамир

“УБТЗ” ХНН-ийн Статистик бүртгэл, мэдээллийн технологийн албаны дарга;

М.Ижилболд

“УБТЗ” ХНН-ийн Статистик бүртгэл, мэдээллийн технологийн албаны Мэдээллийн технологийн хэлтсийн дарга

Б.Содбаяр

“УБТЗ” ХНН-ийн Статистик бүртгэл, мэдээллийн технологийн албаны өгөгдлийн сангийн захирагч

И.Нэргүй

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын Мэдээллийн технологийн хэлтсийн дарга;

Д.Өсөхбаяр

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын Мэдээллийн технологийн хэлтсийн програмист;



Б.Пүрэвдорж	“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын Мэдээллийн технологийн хэлтсийн өгөгдлийн сангийн шинжээч;
Б.Наранбат	“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын Дэд захирал;
О.Лхагвасурэн	“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн хэлтсийн дарга;
П.Бямбабаатар	“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын Мэдээллийн технологийн мэргэжилтэн;
Ч.Нарантунгалаг	“МИАТ” ТӨХК-ийн Мэдээллийн технологи хөгжүүлэлтийн хэлтсийн дарга;
М.Даваа	“МИАТ” ТӨХК-ийн Мэдээллийн технологи хөгжүүлэлтийн хэлтсийн ахлах инженер
Б.Батбаяр	“МИАТ” ТӨХК-ийн Мэдээллийн технологи хөгжүүлэлтийн хэлтсийн сүлжээний инженер
Б.Гүрбазар	“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Мэдээллийн технологийн инженер;
Г.Пүрэвцогт	“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Хүний нөөцийн менежер
Д.Амартувшин	“Далайн захиргаа” ТӨҮГ-ын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга
Г.Гаяпа	“Далайн захиргаа” ТӨҮГ-ын Мэдээллийн технологийн мэргэжилтэн;
О.Пүрэвзул	“Буян-Ухаа Олон Улсын нисэх буудал” Теле мэдээлэл, холбооны албаны дарга;
М.Буянхишиг	“Буян-Ухаа Олон Улсын нисэх буудал”-ын Теле мэдээлэл, холбооны албаны програм хангамжийн инженер
Б.Мөнхзул	“Буян-Ухаа Олон Улсын нисэх буудал”-ын Теле мэдээлэл, холбооны албаны техник хангамжийн инженер
Г.Чангас	“Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ-ын Тээврийн нэгдсэн удирдлага, автоматжуулалт судалгааны хэлтсийн Технологи, автоматжуулалт, судалгаа хариуцсан ахлах мэргэжилтэн;
Г.Баттөр	“Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ-ын програм хангамж, радио зурvas, сүлжээ хариуцсан мэргэжилтэн;
Т.Мейрамбек	“Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ-ын Тээврийн нэгдсэн удирдлага, автоматжуулалт судалгааны хэлтсийн Технологи, автоматжуулалт, судалгааны мэргэжилтэн;

Нарийн бичгийн дарга:

Зам, тээврийн хөгжлийн яамны Мэдээллийн технологи, стандартын хэлтсийн шинжээч

Зам, тээврийн хөгжлийн сайдын  
2021 оны 02 дугээр сарын 01-ны өдрийн  
A/08 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

## УДИРДАМЖ

### Нэг. Зорилго

Зам, тээврийн салбар 2021 оныг “Техник, технологийн шинэчлэлт-цахим шилжилтийн жил” болгон зарласантай холбогдуулан төрийн үйл ажиллагааны процессыг хялбаршуулах, иргэд аж ахуйн нэгжид чиглэсэн салбарын үйлчилгээг шуурхай хүргэх хүрээнд цахим шилжилтийг зохион байгуулж бодлогын удирдамжаар хангаж ажиллана.

### Хоёр. Ажлын зохион байгуулалт

2.1. Ажлын хэсэг нь яам болон харьяа байгууллагуудын мэдээллийн технологийн нэгжийн удирдлага, албан хаагч, бусад холбогдох мэргэжлийн албан тушаалтнуудаас бүрдэх бөгөөд Ажлын хэсгийн ахлагчаас өгсөн үүрэг даалгавар, чиглэлийн дагуу гишүүд зөвлөлдөх уулзалт, дүн шинжилгээ хийж, бичгээр зөвлөмж гаргах хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулна.

2.2. Ажлын хэсгээс гаргасан санал, зөвлөмжийг Ажлын хэсгийн ахлагч Зам, тээврийн хөгжлийн сайдад танилцуулна.

### Гурав. Хэрэгжүүлэх ажлууд

3.1. Зам, тээврийн салбарын үйл ажиллагааг цахимжуулахтай холбогдуулан өнөөгийн нөхцөл байдлын судалгааг гаргаж, цахим шилжилт хийх шаардлагатай нөөц боломжийг тодорхойлох;

3.2. Салбарын байгууллагуудын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа мэдээллийн системүүдийг уялдуулж, мэдээллийн нэгдсэн платформ байгуулах чиглэлээр санал зөвлөмж гаргах;

3.3. “Зам, тээврийн салбарын стратеги, төлөвлөгөө”-ний хавсралтаар батлагдсан “Зам, тээврийн салбарын үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах дунд хугацааны дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд бодлогын удирдамжаар хангах, хяналт тавих;

3.4. Дэд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх зарим чиг үүргийг хувийн хэвшлийн мэдээллийн технологийн томоохон дэд бүтэцтэй чадавх сайтай байгууллагад гэрээгээр хариуцуулан гүйцэтгүүлэх талаар санал боловсруулах;

3.5. Салбарын үйлчилгээ, үйл ажиллагааны процессуудыг энтерпрайз архитектурын түвшинд ре-инженеринг хийх замаар хооронд нь уялдуулах ажлыг нэгдсэн бодлого, арга зүйгээр хангах;

3.6. Цахим шилжилтийг хийхтэй холбоотойгоор батлагдсан бодлого, хөтөлбөрт туссан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн хэмжээг тодорхойлох, төр хувийн хэвшлийн түншлэл, улсын төсөв, гадаадын зээл тусламжаар гүйцэтгэх талаар санал гаргах, хэрэгжилтийг хангуюулж ажиллахад харьяа байгууллагуудад чиглэл, зөвлөмж өгөх;

3.7. Салбарын цахим шилжилтийн талаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд таниулах, сурталчлах үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн олон сувгаар зохион байгуулах ажилд чиглэл өгөх;

### Дөрөв. Үр дүн

Ажлын хэсэг нь удирдамжид тусгагдсан чиглэлээр ажиллаж, жил бүрийн ажлын үр дүнг дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан Зам, тээврийн хөгжлийн сайдад танилцуулна.